

ДХИС-ИЙН ОБС-ИЙН ТӨГСӨХ 641, 643 ДУГААР ДАМЖААНЫ
СОНСОГЧДЫН “СУРГАЛТЫН ТОГЛОЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ”
СУДАЛГАА

Х.Сүхбаатар¹, Ц.Баясгалан², Г.Ганчимэг³, Г.Хатанбаатар⁴,
Г.Чулуунбаатар⁵, Л.Булгахангай⁶, Н.Одмаа⁷
Судалгааны багийн ахлагч, ДХИС-ийн ОБС-ийн захирал, хурандаа¹
ЭЗНАТТ-ийн ахлах багш, доктор, дэд профессор,энэ² ГХАТ-
ийн дэд профессор, хошууч³, ахлах багш, хошууч⁴
ГХАТ багш, ахмад⁵, ГТТАТ⁶ багш, ахлах дэслэгч,, ЭЗНАТТ⁷ -ийн багш, дэслэгч

Хураангуй

Энэхүү судалгааны ажил нь сургалтын тоглолтод сургалтын идэвхтэй олон аргуудыг хэрхэн дэмжих, түүнийг хэрэгжүүлэх тухай өгүүлнэ. Судалгааны ажлаараа судалсан мэргэжлийн хичээлүүдийн талаар үндсэн ойлголт, төсөөллийг олж авахын тулд уламжлалт заах аргыг хэрэглэхээс илүүтэйгээр харилцан ярилцах, бодит жишээнээс суралцах, асуудал дэвшүүлэх, асуудлыг шийдвэрлэх, дүрд оролцогч дэмжих зэрэг аргыг хэрэглэснээр сургалтын үйл ажиллагаа үр дүнтэй, бүтээлч байх боломжийг онолд суурилсан судалсан. Судалгааны ажлыг хийх явцдаа сонсогчдыг хариуцлагатай байлгах, бүтээлчээр сэтгэх, багаараа харилцан ярилцах гэх мэт чадваруудыг хөгжүүлэх зорилгоор сургалтын тоглолтын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхийн тулд тусгайлан боловсруулсан асуултаар чанарын судалгааны арга зүйгээр боловсруулалт хийсэн.

Идэвхтэй сургалтыг сонгон сургалтын тоглолтыг зохион байгуулсан нь бусад сургалтуудтай харьцуулахад сонсогчдын оролцооны үйл ажиллагаа, хүлээн авах байдал өөр байсан нь судалгааны ажлын анхны дүгнэлтээр гарсан. Өгөгдсөн цагийн байдалд боловсруулалт хийх, асуудал шийдвэрлэхэд суурилсан сургалтыг харилцан яриатай хослуулах, орчин үед эрэлт хэрэгцээ өндөр байгаа технологийн тогтвортой, цогц салбарын талаар хичээл явуулахад туйлын хэрэгцээтэй болох нь бидний сургалтын тоглолт болон судалгааны ажлын гүйцэтгэлээр тогтоогдсон. Судалгаанд нийт сургалтын тоглолтод хамрагдсан Дотоод Хэргийн Их Сургуулийн Онцгой байдлын сургуулийн 641,643 дугаар дамжааны 40 сонсогч оролцож, судалгааны үр дүнг Smart-PLS-3.0, SPSS-23 програм, Excel програмаар жишин харьцуулах, дүгнэх, нэгтгэх аргыг хэрэглэн боловсрууллаа.

Түлхүүр үг: Танхимын сургалт, хээрийн гаралт, чиглүүлэх үйл ажиллагаа

Танилцуулга

Онцгой байдлын албанд ажиллах мэргэжилтнүүд баримт мэдээлэл дээр тулгуурласан, судалгааны суурь мэдлэгтэй болж төгсөн гарахыг хурдацтай өөрчлөгдөж байдаг салбарын үйл ажиллагаа шаардаж байна. Олон улсын дээд боловсролын сургалтад ихэвчлэн нэг талын харилцааг заадаг бөгөөд оюутнууд ихэнх тохиолдолд сонсогч эсвэл дагагчийн үүрэгтэй суралцдаг арга хоцрогдсон. Ихэнх хичээлүүд нь эхлээд лекц хичээл ороод дараа нь 30 орчим оюутантай баг болгон хуваагаад ярилцлагын зарчмаар явагддаг. Иймээс өнөө үед уламжлалт заах аргын чиг хандлага өөрчлөгдөж багш хичээл заахаас илүүтэйгээр оюутан суралцах тал руу чиглэгдсэнээр оюутнуудын хариуцлага илүү нэмэгдэж байна. Хичээлийн мэдлэг,

ойлголтыг олж авахад харилцан яриа ашиглан үзэл бодлоо илэрхийлэх, өөртөө дүгнэлт хийх зэрэг дасгал ажлуудыг ашигласнаар уламжлалт заах аргаас илүү үр дүнтэй байдаг. Багш асууж оюутан хариулдаг хэлбэрээр хичээл явуулахын оронд бодит үйлдэл, дадлага хийх нь чухал. Иймээс бодит дадлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд багш оюутнууд хоорондоо харилцан ярилцах нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Салбар салбарт өөр өөр арга хэрэглэн сургалтыг үр дүнтэй бүтээлч болгох үр дүн хэрэгжиж эхлэн дараа дараагийн сургалтыг ач холбогдлыг тодорхойлсоор байна. Жишээ нь, инженерийн ухааны гол цөм болох Сэтгэх, Зохиох, Бүтээх, Хэрэглэх /C: Conceive, D: Design, I: Implement and O: Operate / гэсэн 4 үндсэн үйл ажиллагаанд суурилдаг CDIO хөтөлбөрийг боловсролын тогтолцоонд хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ. CDIO хөтөлбөрт суурилсан хичээлийн хөтөлбөр нь тухайн нэгэн хичээлийн техникийн үндсэн ойлголтуудыг хувь хүн болон хүмүүс хоорондын болон, бүтээгдэхүүний системийг сайжруулах чадваруудыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Мөн асуудалд суурилсан сургалтын үр дүн, ач холбогдлыг олон эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн байдаг. Асуудалд суурилсан сургалт гэдэг нь оюутнууд бодит кэйсэд тулгарсан асуудлууд дээр ажиллах, шинжлэх ухааны мэдлэгээ сайжруулах мөн тухайн асуудлыг шийдвэрлэхийн тулд цаашдын мэдлэг, мэдээллийн идэвхтэй хайх чадварыг хөгжүүлэхийг хэлдэг.

Судлагдсан байдал

Идэвхтэй сургалтын аргын талаар манай улсын эрдэмтэд нэлээд судалгааг хийн эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгт хэлэлцүүлсэн байдаг. Үүнд:

П.Аюурзана, Ж.Хашбат ба бусад, /2017, ШУТИС, МТС/ багш нар “Идэвхтэй сургалт явуулах арга зүйн зөвлөмж” судалгааны ажлаараа, Сургалтын идэвхтэй аргууд нь оюутнуудыг бодож сэтгэх болон асуудал шийдэх үйл ажиллагаанд шууд татан оролцуулна. Оюутнууд сонссон зүйлийнхээ талын талаас багыг, сонссон, харсан зүйлийнхээ зөвхөн талыг санадаг. Оюутнуудыг ойлголтын талаар тухайлбал шинэ санааг бодож сэтгүүлэх, нээлттэй хариулт шаардах үед оюутнууд илүү их суралцаад зогсохгүй юуг хэрхэн сурч байгаагаа

өөрсдөө танин мэднэ. Танин мэдэхүйн энэ процесс хөтөлбөрийн сургалтын үр дүнд хүрэх гэсэн оюутнуудын хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэхэд, амьдралын турш суралцах дадал зуршлыг бий болгоход тусална. Идэвхтэй сургалтын аргуудын үед багш оюутнуудад гол ойлголтуудын хооронд холболт хийхэд нь, мөн энэ мэдлэгийг шинэ нөхцөлд хэрэглэхэд нь зааж тусална гэж нарийвчлан тодорхойлж өгсөн байдаг.

Судалгааны ажлын зорилго:

Сонсогчдын онолын мэдлэгийг дээшлүүлэх, сургах арга зүй болон сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэн сонсогчдын мэдлэг, ур чадвар, хандлага, хээрийн гаралтын бэлтгэл бэлэн байдал зэргийг харгалзан сургалтын тоглолтын үр дүнг тодорхойлоход хувь нэмэр оруулахад оршино.

Судалгааны ажлын зорилт:

- Идэвхтэй сургалтын арга хэрэглэдэг их дээд сургуулиудын туршлагаас суралцах
- Идэвхтэй сургалтын аргаас туршин сургалт явуулах
- Идэвхтэй сургалтын аргыг тусгасан судалгааны асуулт боловсруулж зорилтот бүлгээс судалгаа авч харьцуулалт хийн үр дүнг гарган дүгнэх

Судалгааны ажлын оролцогчид:

Дотоод Хэргийн Их Сургуулийн Онцгой байдлын сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн төгсөх 641,643 дугаар дамжааны сонсогчид хамрагдсан.

Судалгааны аргууд:

Уг судалгаанд судалгааны дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

- Асуулгынарга, Туршилтын арга, Харьцуулалтын арга, Чанарын судалгааны арга ...

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол:

Сургалтын тоглолтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, үр дүнг нэгтгэн, сургалтын тоглолтын гүйцэтгэлд нөлөөлөх гурван хүчин зүйлийг таамаглал болгон дэвшүүлж, чанарын судалгаа авсан. Судалгаанд оролцсон сонсогчдоос үр дүн, гүйцэтгэлд санал авч дараа дараагийн сургалтын тоглолт зохион байгуулах ажилд тусгах болсон.

1. Идэвхтэй сургалтын аргын онол арга зүй

1.1. Идэвхтэй сургалтын аргууд

Сургалтын арга нь сургалтын технологийн хамгийн чухал элемент бөгөөд түүний үндсэн үүрэг нь сургалтын зорилго, агуулга зэргийг багшийн сурган хүмүүжүүлэх болон сурагчийн сурч хөгжих арга ажиллагаагаар дамжуулж хэрэгжүүлэх явдал юм. Философийн толь бичигт Арга гэдэг нь зорилгодоо хүрэх зам юм гэсэн байдаг.

Сургалт хүн бүрийн хувьд хамгийн чухал зүйл байдаг. Сайн сурч боловсрон, мэдлэг чадвар өндөртэй болбол, тухайн хүүхдийн ирээдүй гэрэлтэж,

чадварлаг боловсон хүчин болж төлөвшдөг. Гэвч зарим хүүхэд, оюутнууд яаж сурах, хэрхэн хичээлд дурлах тал дээр бага зэрэг асуудалтай байдаг нь нууц биш. Иймд таны хүүхэд болоод оюутан залууст хэрэг болох хичээлийг илүү сонирхолтой, хялбар болгох аргуудыг танилцуулах нэн чухал.

Талхны үйлдвэр талх хийхдээ ямар ч байсан яах вэ гээд талх хийдэггүй тэд хэрэглэгчдэд таалагдсан сайхан амт чанартай бүтээгдэхүүн хийхийг тулд орц, хийх нөхцөл зэргээ сайтар бодож хийдэг шиг бидний төлөвлөсөн хичээл эцсийн эцэст оюутнуудад таалагдаж, тэд сэтгэл хангалуун байх ёстой. Нэг үе мэдлэг, чадвар, төлөвшилт хэмээн дэс дараалалтай сургалтын процесс явагддаг байсан бол өнөөдөр аливаа зүйлийг сурах, бүтээх гэсэн чин эрмэлзэл, хандлагатай байх нь суралцагчдад чухал болоод байна. Үүнтэй уялдан шинэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд сургалтын агуулга, багш, оюутны хандлага, сурах, сургах арга, үнэлгээ зэрэг сургалтын технологи, хичээл төлөвлөлт зэрэг нь өөрчлөгдөхөөс өөр аргагүй болно. Өнөө үед сургахын тухай биш, суралцахуйн тухай ярих нь илүү оновчтой асуудал боллоо. Суралцахуй бол сэтгэл зүйн хувьд ямар ч айдас түгшүүргүй, аятай тайван орчин бүрдсэн, суралцагч нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой, итгэлцэл, харилцан ойлголцол бий болсон нөхцөлд амжилттай явагдаж үр дүн нь мэдрэгдэх онцлогтой зүйл юм. Суралцахуйн онолыг хөгжүүлж ирсэн 3 үзэл баримтлал байдгаас оюутнуудын хүсэл, сонирхол, хандлага, төлөвшил, сэтгэл зүй гээд хөгжих гэсэн хүсэл эрмэлзэлтэй, хувь хүний эрэлт хэрэгцээнд илүү тулгуурласан байх нь багш бидний өмнө тулгарч буй зорилтуудын нэг болно. Ихэнх багш нар нэг хичээлд хоёр эсвэл түүнээс олон идэвхтэй болон туршилттай сургалтын аргуудыг нэгтгэн хэрэглэх нь оновчтой байдаг.

Харвардын профессор Эрик Мазур 1990-ээд оны эхээр анх санаачилсан “Бие биенээсээ суралцах сургалт”-Peer instruction” сургалт нь баталгаанд суурилагдсан, оюутан төвтэй сургалтын арга. Энэ сургалтыг Анх Харвардын их сургуулийн физикийн хичээлд хэрэглэж байсан бол өнөөдөр дэлхийн тэргүүлэгч ихэнхи их дээд сургуулийн төрөл бүрийн хичээлд хэрэглэж байна. Энэ сургалтаар тухайн сэдвийн үндсэн санааг ойлгох оюутнуудын ойлголтыг эрс сайжруулж байна. “Peer Instruction (PI) -Бие биенээсээ суралцах арга” нь тухайн материалын хүнд хэцүү асуудлуудыг шийдүүлэхэд оюутнуудыг татан оролцуулж ангид харилцан суралцуулах сурганы арга. Лекц, семинарын хичээл дээр ойлголтынхоо талаар хэлэлцүүлэг хийх боломжийг оюутнуудад олгосноор бие биенээсээ суралцахыг зөвшөөрнө. Оюутнууд тухайн сургалтын материалын талаар зарим нэг үндсэн ойлголттой болж ангид ирэх үед энэ арга маш их үр өгөөж өгнө.

Дээрхээс гадна, яг цагтаа суралцах арга эрдэмтдийн анхаарлыг татсаар байна. Яг цагтаа суралцах сургалт нь багш нарын бэлтгэл ажилд тустай төдийгүй мөн оюутнуудад ангийн хичээлд бэлтгэхэд тус болно. Яг цагтаа суралцах

сургалтыг бие биенээсээ суралцах сургалттай хослуулснаар ялангуяа хичээлийн цагт бэлтгэх бэлтгэл ажлыг илүү үр өгөөжтэй болгохын зэрэгцээ ойлголтын талаарх хамгийн сайн тест сонгохыг илүү хялбар болгоно. Ихэнх тохиолдолд оюутны асуудал эсвэл тэдний буруу ташаа ойлголтыг мэдсэнээр шинэ нэмэлт асуултууд зохиох шинэ санаа төрдөг. Хэлэлцүүлэг хийхийн өмнө ойлголтын тестийн зөв хариулт 30–70% байх үед бие биенээсээ CDIO арга зүйн зөвлөмж суралцах хэлэлцүүлэг оюутнуудад хамгийн их үр өгөөжтэй байгааг Америкийн физикийн багш нарын холбооны судалгаа харуулсан байдаг.

Бодит байдалд суралцах аргыг хэдийгээр хууль, бизнес, анагаахын боловсролд анх хэрэглэж байсан. Бодит нөхцөл байдлыг хэлэлцэн ярилцсанаар оюутнууд бодит орчны үйл ажиллагаанд шууд бус байдлаар дадлага хийж, асуудал, бэрхшээлийг шийдэхэд оролцоно. Бодит байдалд суралцах аргын зорилго нь бодит орчинд практик дадлага хийлгэж оюутнуудын бие даан шийдвэр гаргах болон сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд оршино. Бодит байдалд суралцах аргыг хэрэглэдэг багш нар энэ сургах суралцах арга нь оюутны задлан шинжлэх болон шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэхэд болон илүү хэцүү асуудалд шийдвэр гаргахад нь тус нэмэр болж байдаг.

Багш болгон сургалтын үр дүнтэй болгох зорилгоор мэдлэг туршлагатай байхыг хүсдэг билээ. Учир нь ажил мэргэжилдээ амжилттай байхын эхлэл юм. Хичээл заах арга барилын талаар ерөнхий ойлголт байдаг ч хичээлийг илүү идэвхтэй, сонирхолтой болгохын тулд зарим нэг онцгой арга бас бий. Идэвхтэй сургалтын аргуудын жишээ

Хүснэгт 1.1. Идэвхтэй болон туршилттай сургалтын аргуудын ялгаа

Идэвхтэй сургалтын арга	Туршилттай сургалт
-------------------------	--------------------

Оюутнууд сэтгэн бодох Асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох Багаар ажиллах Дүрд орлон тоглох Өөрийн үүрэгт ажлын гүйцэтгэлийг илтгэх Тодорхой хугацаагаар даалгаврыг ахин гүйцэтгэн ахиц дэвшил гаргах Хайгуул хийх, шинэ санаа гаргах	Мэргэжлийн зарим практик ажлыг дуурайлган гүйцэтгүүлэх Тодорхой хугацаанд даалгавар гүйцэтгэн уралдах Тусгай багаж хэрэгсэлтэй ажиллах Үзүүлэн макет ашиглах, биеэр хүрч мэдрэх Багийн үйл ажиллагаагаар нэгдсэн даалгавар гүйцэтгүүлэх
Сургалтын тоглолтод ашигласан арга	
Оюутнууд сэтгэн бодох Асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох Багаар ажиллах Дүрд орлон тоглох Өөрийн үүрэгт ажлын гүйцэтгэлийг илтгэх Тодорхой хугацаагаар даалгаврыг ахин гүйцэтгэн ахиц дэвшил гаргах Хайгуул хийх, шинэ санаа гаргах Мэргэжлийн зарим практик ажлыг дуурайлган гүйцэтгүүлэх Тодорхой хугацаанд даалгавар гүйцэтгэн уралдах Үзүүлэн макет ашиглах, биеэр хүрч мэдрэх.....	

Эх үүсвэр: П.Аюурзана, бусад, /2017, ШУТИС, МТС/ CDIO арга зүйн зөвлөмж, гарын авлага, 2017 он.

Оюутнуудын дүрд орлон тоглуулахад оролцогчдын хоорондын харилцаа, дүрийг амилуулах явцад тэдний хооронд явагдах харилцан яриа нь сурагчдын харилцааны хийгээд хэл ярианы соёл хөгжиж төлөвшихөд маш чухал ач холбогдолтой байхын зэрэгцээ дээрх хүснэгтэд үзүүлсэн олон үзүүлэлт нэг зэрэг даалгаварт багтан гүйцэтгэлд эерэгээр нөлөөлдөг.

Сургалтын үйл ажиллагааг бүтээлч, сонирхолтой болгохын тулд тоглоомын арга, сэдэлжүүлэлтийг өргөн ашигладаг. Тоглоомын аргаар сургах нь эртний Грек, Ромын үеийн Платон зэрэг сурган хүмүүжүүлэгчид, сэтгэгчдээс эхлэлтэй. Сургалтын үүднээс тоглоом бол сэдэлжүүлэх, сурсныг бататгах ой тогтоолтын болон хичээлийн явцад идэвхжүүлэх, биеэ авч явах зан үйл, нийгэмшилд сургах үр дүнтэй, чухал хэрэгсэл. Тоглоомын хамгийн чухал шинж чанар бол Fun-зугаатай, хөгжилтэй байдал бий болгодог ач холбогдолтой. Сургалтад тоглоом ашиглана гээд олон багш ихээхэн цаг хугацаа, материал шаардах тоглоомуудыг бодож, хайж хүндрүүлдэг. Үүний оронд цаг хугацаа, материал бага шаардах тоглоомуудыг эрэлхийлэх хэрэгтэй. Сургалтын сэдэв агуулгатай нийцсэн бодит жишээ уншиж, тэрхүү жишээгээр илүү сонирхолтой байдлаар үргэлжлүүлэх боломж олгож байвал оролцогчид аль болох хөгжилтэй инээж байвал энэ бол fun-хөгжилтэй, зугаатай байдал. Багш хүн үүнд байнга тэмүүлж байх учиртай. Харин тоглоомыг сургалтын үр дүнтэй арга гээд хэт туйлширч, сонирхолгүй байхад хүчээр тоглуулах нь тоглоом биш болно. Тоглоомын арга нь оюутнуудын дараах чадваруудыг хөгжүүлдэг. Үүнд:

- Логик сэтгэлгээ, стратеги бодож боловсруулах
- Учир, уялдаа холбоог ойлгох

- Төсөөлөн бодох
- Бүтээлч сэтгэлгээ
- Урьдчилан таамаглах, асуудал шийдвэрлэх
- Оюуны когнитив үйл ажиллагаа
- Үйлдлийн дэс дарааллыг баримтлах
- Хамтран ажиллах
- Анхаарал төвлөрөх
- Сонирхол төрүүлэх
- Мэдлэгийг бататгах, дасгалжуулах

Тоглоомын арга бол маш чухал сурах, сургах арга. Тоглоомын аргаар сурсан тухайн сэдэв агуулга дах бүхий ойлголт нь үндсэн нэр томьёо, сэдвээ бататгаж, дасгал хийж, амархан мартахааргүйгээр, удаан хугацааны ой тогтоолтод хадгалах зорилгоор зориуд хичээлд ашигладаг. Учир нь хүн өдөр

тутмын энгийн үзэгдэл, байнгын үйлдлийг санахаас илүү онцгой, сэтгэл хөдөлгөсөн, хөгжилтэй, өөрийн идэвхтэй үйлдсэн үйлийг илүүтэй санадаг.

Сургалтад тоглоомын арга ашигласнаар оюутнуудын сурах, ойлгох сэдэл тэмүүллийг нэмэгдүүлдэг нь судалгаагаар нотлогдсон. Өөрөөр хэлбэл бэлтгэл ажилд хугацаа бага шаарддаг, тоглоход хялбар ойлгомжтой, сэтгэн бодох чадвар шалгасан, хөгжөөнтэй тоглоомуудыг сонгох нь чухал. Тоглоомыг тоглуулахад хэд хэдэн зүйлийг анхаарах нь зүйтэй. Үүнд:


- Багш тоглоомын зааврыг сайн тайлбарлан өөрөө удирдах хэрэгтэй ингэх нь оюутнуудад багш бол шүүгч гэсэн ойлголт төрүүлнэ.

- Тоглоомыг дүрмийг дагах нь чухал. Энэ нь оюутнуудын дунд үл ойлголцол, маргаан үүсэхээс сэргийлнэ.

- Багаар тоглож байгаа үед оюутнуудын өрсөлдөх чадвар тэнцүү байхаар хуваарилалт хийх хэрэгтэй. Энэ нь тоглоомыг илүү сонирхолтой бас үр дүнтэй болгодог төдийгүй дахин тоглоом тоглох бүрд шинээр баг хуваарилах шаардлагагүй.

Дээрх идэвхтэй сургалтын аргуудыг сонсогчдын сургалтын тоглолтод хэрэглэх боломжтой байсан. Удирдамжид заасны дагуу манай сонсогчид, багаар ажиллах, хэлэлцэх, илтгэх, тоглох, дүрд орлон тоглох зэрэг аргыг хэрэглэж байгаа тул сургалтын идэвхтэй онолын үзэл баримтлал дээр тулгуурлан судалгааны багийн судлаачид дараах таамаглал дэвшүүлж загвар боловсруулж чанарын судалгаа хийлээ /Загвар-1/.

Загвар-1. Сургалтын тоглолтын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйл



T-1: Танхимын сургалтын үйл ажиллагаа сургалтын тоглолтын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө.

T-2: Хээрийн гаралтын үйл ажиллагаа сургалтын тоглолтын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө.

T-3: Чиглүүлэх үйл ажиллагаа сургалтын тоглолтын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө.

2. Сургалтын тоглолтын үр дүнг үнэлсэн судалгааны боловсруулалт

Судалгааны зорилго:

“Аюулгүй байдал-гамшгаас хамгаалах алба”, “Эдийн засаг-улсын нөөц, ар тал хангалт” хөтөлбөрөөр байгаа 2019-2020 оны хичээлийн жилд 641, 643 дугаар дамжаанд суралцаж сонсогчдын суралцах явцад сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын тоглолтын үр дүн, гүйцэтгэлийг судлахад чиглэнэ.

Судалгааны зорилт:

- Сонсогчдын сургалтын тоглолтын үйл ажиллагааны оюутны сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийг судлах
- Танхимын сургалтаар олж авсан онолын мэдлэг, ур чадвар, хандлагыг дадлага ажилд хэрхэн хэрэглэх арга зүйг дүгнэх
- Судалгааны ажлын гарын авлага гарган дараа дараагийн хичээлийн жилд суурь судалгаа болгон ашиглах

Судалгааны хүрэх үр дүн, ач холбогдол:

- Судалгаанд оролцогчдын мэдээлэлд шинжилгээ хийн, үр дүнгээс дүгнэлт гарган удирдлагад танилцуулан тайлагнах
- Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, хөндлөнгийн үнэлгээ хийхэд сонсогчдын өгсөн санал, зөвлөмжийг хэлэлцэх
- Судалгааны үр дүн, гарах шийдвэрийг сургалтын тоглолт зохион байгуулахад тусгах зэрэг болно.

Судалгааны таамаглал:

Бид олон эрдэмтдийн судалгааны ажилтай танилцсаны үр дүнд таамаглалыг дэвшүүлэн судалгааны загвар боловсруулж, хамааралтай болон хамааралгүй хувьсагчийг дараах байдлаар илэрхийлсэн.


• **Хамаарах хувьсагчид:** *танхимын сургалтын үйл ажиллагаа, хээрийн гаралтын үйл ажиллагаа, чиглүүлэх үйл ажиллагаа*

• **Үл хамаарах хувьсагч:** *сургалтын тоглолтын гүйцэтгэлийн менежмент*

3. Судалгааны боловсруулалт

Судалгаанд нийт 40 оролцогч хамрагдсанаас шаардлага хангасан судалгаа 40, ямар нэгэн мэдээлэл дутуу, шаардлага хангаагүй судалгаа байсангүй. Судалгааны баг сонсогчдын ерөнхий мэдээлэлд бага ач холбогдол өгсөн ба тэдний нас, хүйс зэрэг ерөнхий мэдээллийг авахыг зорилго болгоогүй. Хамгийн гол нь таамаглаж байгаа гурван хүчин зүйлийн далд хувьсагчдаас хайж байгаа асуудлаа тодорхойлохыг хичээсэн.

Загвар 2.1. Сургалтын тоглолтын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээний үр дүн



Тайлбар: са-танхимын сургалтын үйл ажиллагаа, ра-хээрийн гаралтын үйл ажиллагаа, да-чиглүүлэх үйл ажиллагаа, рт-сургалтын тоглолтын гүйцэтгэлийн менежмент

Хүснэгт 2.1. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн

Variable of model	Items	Factor Loading	Average Variance Extracted	Cronbach's Alpha	Composite Reliability
Танхимын сургалтын үйл ажиллагаа	ca-1	0.603	0.443	0.745	0.824
	ca-2	0.515			
	ca-3	0.714			
	ca-4	0.664			
	ca-5	0.634			
	ca-6	0.823			
Хээрийн гаралтын үйл ажиллагаа	pa-1	0.728	0.460	0.735	0.789
	pa-2	0.903			
	pa-3	0.664			
	pa-4	0.688			
	pa-5	0.200			
Чиглүүлэх үйл ажиллагаа	da-1	0.846	0.679	0.906	0.927
	da-2	0.855			
	da-3	0.817			
	da-4	0.841			
	da-5	0.843			

Тайлбар: са-танхимын сургалтын үйл ажиллагаа, ра-хээрийн гаралтын үйл ажиллагаа, да-чиглүүлэх үйл ажиллагаа, рт-сургалтын тоглолтын гүйцэтгэлийн менежмент

Судалгааг сүүлийн үеийн чанарын судалгааны арга зүйд өргөн хэрэглэн олон хүчин зүйлийн шинжилгээний **SMART PLS 3.0** програмаар үр дүнг гаргасан.Үүнд:

1. Судалгааны тоон мэдээллийг тусгайлан тэмдэгтээр кодолж програмд оруулсан.
2. Судалгаанд таамаглал болгон дэвшүүлсэн загварыг програмд таниулсан.
3. Судалгааны мэдээллийн баазыг загвартаа таниулж мэдээллээ

баталгаажуулж шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүнг танилцуулбал, Танхимын сургалтын үйл ажиллагааг 6 далд хувьсагчаар судалсан. Далд хувьсагчдын утга **0.515-0.823** утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал-**0.824**, дундаж утга-**0.443**, Кронпа альфа утга-**0.745** үр дүнтэй байна.

Хээрийн гаралтын үйл ажиллагааг 5 далд хувьсагчаар судалсан. Далд хувьсагчдын утга **0.200-0.903** утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал-**0.789**, дундаж утга-**0.460**, Кронпа альфа утга-**0.735** үр дүнтэй байна.

Чиглүүлэх үйл ажиллагааг 6 далд хувьсагчаар судалсан. Далд хувьсагчдын утга **0.738-0.855** утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал-**0.927**, дундаж утга-**0.679**, Кронпа альфа утга-**0.906** үр дүнтэй байна.

Сургалтын тоглолтын гүйцэтгэлийн менежментийг 6 далд хувьсагчаар судалсан. Далд хувьсагчдын утга **0.193-0.817** утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал-**0.775**, дундаж утга-**0.388**, Кронпа альфа утга- **0.648** үр дүнтэй байна.

Хүснэгт 2.2. Далд хувьсагчийн хамаарлын шинжилгээ

№	Хүчин зүйлс	Сургалтын тоглолтын гүйцэтгэл	Танхимын сургалтын үйл ажиллагаа	Хээрийн гаралтын үйл ажиллагаа	Чиглүүлэх үйл ажиллагаа
1	Сургалтын тоглолтын гүйцэтгэл	0.623			
2	Танхимын сургалтын үйл ажиллагаа	0.684	0.666		
3	Хээрийн гаралтын үйл ажиллагаа	0.380	0.614	0.678	
4	Чиглүүлэх үйл ажиллагаа	0.579	0.562	0.588	0.824

Тайлбар: Судалгааны багийн үр дүн

Сургалтын тоглолтын гүйцэтгэл хоорондын хамаарал-0.623, сургалтын тоглолтын гүйцэтгэл болон танхимын сургалтын үйл ажиллагаа-0.684, сургалтын тоглолтын гүйцэтгэл ба хээрийн гаралтын үйл ажиллагаа хоорондын хамаарал-0.380, сургалтын тоглолтын гүйцэтгэл ба чиглүүлэх үйл ажиллагаа хоорондын хамаарал-0.579 тус тус хамааралтай байгаагаас хамгийн сайн хамааралтай байгаа сургалтын тоглолтын гүйцэтгэл, дундаж хамааралтай байгаа нь сургалтын тоглолтын гүйцэтгэл ба танхимын сургалтын үйл ажиллагаа, чиглүүлэх үйл ажиллагаа хамааралтай байна.

Хамгийн бага хамааралтай нь сургалтын тоглолтын гүйцэтгэл ба хээрийн гаралтын үйл ажиллагаа хоорондын хамаарал-0.380 үр дүнтэй байна. Танхимын сургалтын үйл ажиллагааны хоорондын хамаарал-0.666, танхимын сургалтын үйл ажиллагаа ба хээрийн гаралтын хамаарал-0.614, танхимын сургалтын үйл ажиллагаа ба чиглүүлэх үйл ажиллагааны хамаарал-0.562, хээрийн гаралтын үйл ажиллагаа хоорондын хамаарал-0.678, хээрийн гаралтын үйл ажиллагаа ба

чиглүүлэх үйл ажиллагааны хамаарал-0.588, чиглүүлэх үйл ажиллагааны хоорондын хамаарал-0.824 тус тус үр дүнтэй байна.

Хүснэгт 2.3. Замын шинжилгээний үр дүн

Таамаглалууд	Дундаж утга	Стандарт хэлбэлзэл	t статистик утга	P үнэцэнэ	Үр дүн
таамаглал-1	0.569	0.196	3.097	0.002	дэмжигдсэн
таамаглал-2	-0.053	0.207	0.973	0.331	дэмжигдсэнгүй
таамаглал-3	0.325	0.177	2.017	0.044	дэмжигдсэн

Тайлбар: Судалгааны багийн үр дүн

Замын шинжилгээний үр дүнгээс харахад,

- Таамаглал-1 ба танхимын сургалтын үйл ажиллагаа сургалтын тоглолтын гүйцэтгэлд нөлөөлнө гэсэн таамаглалын P утга **0.002** үр дүнтэйгээр батлагдлаа.

- Таамаглал-2 ба хээрийн гаралтын үйл ажиллагаа сургалтын тоглолтын гүйцэтгэлд нөлөөлнө гэсэн таамаглалын P утга **0.331** үр дүнтэйгээр батлагдсангүй. Таамаглалын хувьд, далд хувьсагчийн утга зарим шаардлагыг бүрэн хангаж чадаагүй үр дүн гарсан.

- Таамаглал-3 ба чиглүүлэх үйл ажиллагаа сургалтын тоглолтын гүйцэтгэлд нөлөөлнө гэсэн таамаглалын P утга **0.044** үр дүнтэйгээр батлагдлаа.

Дүгнэлт

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд төгсөх дамжааны сонсогчид танхимд үзсэн онолын хичээлийг бататган дадлага хийн тоглолт зохион байгуулдаг онцлогтой. Энэ 2019-2020 оны хичээлийн жилд 641,643 дугаар дамжааны сонсогчдын дунд сургалтын тоглолт 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрөөс 12 дугаар сарын 6-ны өдрийг дуустал амжилттай зохион байгуулагдсан. Сургалтын тоглолтын тайланг нэгтгэн сургуулийн архивын материал болгон нэгтгэсэн. Сургалтын тоглолтын гүйцэтгэлийн талаар оролцогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг олон хүчин зүйлээр шинжилсэн. Сургалтын тоглолтод идэвхтэй сургалтын аргуудын хэрэгжилтийг илүүтэй холбон судалсан бөгөөд онол практик хосолсон, бодит жишээнээс суралцаж, дүрд орлон тоглох арга давамгайлсан онцлогтой байсан. Удирдамжид заагдсан бүх үйл ажиллагааг бүрэн хамарсан давуу талтай. Өмнөх хичээлийн жилүүдээс онцлог нь сонсогчдоос судалгаа авч, үр дүнг боловсруулан дүгнэлт гарган удирдлагад танилцуулан дараа дараагийн сургалтын тоглолтод анхаарах хэд хэдэн зүйлд санал нэгдсэнээрээ ач холбогдолтой байсан гэж дүгнэж байна. Дэвшүүлэн таамагласан 3 таамаглалын ерөнхий найдвартай байдлын үр дүн 0.7-оос дээш ба сайн үр дүнтэй байсан бол дундаж утга сургалтын тоглолтын гүйцэтгэл, танхимын сургалтын үйл ажиллагаа, хээрийн гаралтын үйл ажиллагаа зэрэгт 0.5-аас бага байгааг цаашид анхаарах нь зүйтэй гэж дүгнэсэн. Харин чиглүүлэх үйл ажиллагааны дундаж утга /AVE/ -0.679 байгаа нь багш нар чиглүүлэх ажил, үйл ажиллагааг сайн гүйцэтгэсэн гэж дүгнэх боломжтой.

Судалгааны ажлын хязгаарлагдмал байдал

- Зөвхөн нэг загвараар 3 таамаглал дэвшүүлэн судалсан.
- Бусад судалгааны ажилтай харьцуулах боломж бага.
- Өмнөх суурь судалгааны ажилтай харьцуулах боломжгүй.
- Сонсогчдын зарим санал хүсэлтийг бүрэн гүйцэтгэх боломж бага.
- Хугацааны хувьд хязгаарлагдмал.
- Таамаглал-2 батлагдаагүй.